Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн......
дугаар албан бичгийн ..1.. дүгээр хавсралт

XTY6987 9024050917 2117428

# МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ
## (2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР)

2024 оны 12 дугаар сарын 10 — Улаанбаатар хот

| № | ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ** | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр): Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр): Төсөв (сая.төг) | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр): Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | | | | | | |
| ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | | | | | | | | | | |
| 1 | 9.3. Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.<br>9.4. Хууль, эрх зүйн шинэчлэл | 9.3.4. Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй | 1.2021 – 2025<br>2.2024-2027 | | 1.Франц Улсын нэн хөнгөлөлттэй зээл<br>2. Азийн хөгжлийн банкны | 1.60.7 сая евро<br>2.60 сая ам.доллар | | | | | Олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах төслийн ажлууд хийгдэж байна. Үүнд:<br>1.Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн тээврийн шугам байгуулах ажил Хан-Уул дүүргийн Яармагийн эцсийн зогсоолоос Сонгино Хайрхан дүүрэг хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна.<br>2.Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх "Тусгай замын | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ. 9.4. Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ. 9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ. | байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна. | 3.2024-2030 | | хөнгөлөлттэй зээл 3. Нийслэлийн төсөв | 3.337 тэрбум ам.доллар | | | | | автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар" 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг семинарт Far East BRT Planning Co Limited Компани нийтийн тээврийн тусгай замын автобус зорчих трассын талаар танилцуулсан ба Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Урьдчилсан байдлаар Ард-Аюушийн өргөн чөлөө, Их тойруу, Сүхбаатар талбай хүртэлх трассыг хийх ба 2025 оны 01 дүгээр сард загвар зураглалыг бэлэн болгож, 2025 оны 04 дүгээр сард нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтын ажлыг хийхээр төлөвлөсөн. 3.2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигтэй танилцаж, хуралдсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро барих төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан. 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шинжлэх Ухаан Технологийн Их | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хяналтын камер, интернэт, гэрэлтүүлгийг суурилуулах нэмэлт санал хүргүүлсэн.<br><br>Улаанбаатар хотын "Шинэ их тойруу" хурдны замын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын даалгаварт дайран өнгөрч буй хот орчмын бүсүүдийг цаашид дагуул хот болон хөгжих нөхцөлийг хангаж нийтийн тээврийн тусгай эгнээ гаргах, хурдны замын зогсоолын стандартыг боловсруулах, бусад чиглэлүүдийг холбох боломжтой эцсийн зогсоолын зай талбайг шийдэх, нийтийн тээврийн зогсоолын гэрэлтүүлэг, цахим мэдээллийн самбар, дулаан зогсоолын халаалт зэргийг ажиллуулахад шаардагдах цахилгааны эх үүсвэр, дэд бүтцийг шийдвэрлүүлэх саналуудыг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/02/3040 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| Хэрэгжилтийн дундаж хувь: | | | | | | | | | | | | 70 |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА — З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — Ц.БЯМБАСҮРЭН

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн .......
дугаар албан бичгийн 2 дугаар хавсралт

XTY6987 9024050917 2117428

# МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 10 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Бодлогын баримт бичгийн хүрээнд Нийтийн тээврийн бодлогын газраас 1 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ба хэрэгжилтийн дундаж 70 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.3.4. "Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна" гэсэн арга хэмжээ тусгагдсан байна.

Арга хэмжээний хэрэгжилт 70 хувь байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр "Тодорхой үр дүнд хүрсэн" (зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай) үнэлгээтэй байна.

Олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах 3 төслийн ажлууд хийгдэж байна. Үүнд:

1.Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн тээврийн шугам байгуулах ажил Хан-Уул дүүргийн Яармагийн эцсийн зогсоолоос Сонгино Хайрхан дүүрэг хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна.

2.Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх "Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар" 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг семинарт Far East BRT Planning Co Limited Компани нийтийн тээврийн тусгай замын автобус зорчих трассын талаар танилцуулсан ба Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн

чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Урьдчилсан байдлаар Ард-Аюушийн өргөн чөлөө, Их тойруу, Сүхбаатар талбай хүртэлх трассыг хийх ба 2025 оны 01 дүгээр сард загвар зураглалыг бэлэн болгож, 2025 оны 04 дүгээр сард нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтын ажлыг хийхээр төлөвлөсөн.

3.2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигтэй танилцаж, хуралдсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро барих төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан. 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Духуа Инженеринг ХК ба түншлэл нь Улаанбаатар метро төслийн хүний нөөц бэлтгэх чиглэлд хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд метро жолоодлого, удирдлага, механик инженер, метроны цахилгаан, дохиолол, барилгын инженер гэсэн 4 чиглэлд сургалтын хөтөлбөрийг зөвлөх баг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус хөтөлбөртэй Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн холбогдох мэргэжилтнүүд танилцан, саналыг хүргүүлсэн. Одоогоор хамтарсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон хамтран ажиллах Бүгд Найрамдах Солонгос Улсын их сургуулийг тодорхойлох судалгаа, уулзалтууд хийгдсэн.

“Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан нийтийн тээврийн буудалтай байна” арга хэмжээний биелэлт Нийслэлийн гэр хорооллын гудамж, зам талбайд нийтийн тээврийн хүртээмж үйлчилгээг сайжруулах, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2.5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулсан. Грийн групп ХХК- аас 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн 01/158 дугаартай албан бичгийн хүрээнд Нийтийн тээврийн зогсоол шинэчлэх “Грийн боард” төслийг судалж, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр 02/02/1469 дугаартай албан бичиг төлөвлөн Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт /БД 32-101-37/ болон MNS 5873:2012 Нийтийн тээвэр Замналын зогсоол ба түүний байгууламжид тавих нийтлэг шаардлагад нийцүүлэх, мөн иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хяналтын камер, интернэт, гэрэлтүүлгийг суурилуулах нэмэлт санал хүргүүлсэн.

Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны замын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын даалгаварт дайран өнгөрч буй хот орчмын бүсүүдийг цаашид дагуул хот болон хөгжих нөхцөлийг хангаж нийтийн тээврийн тусгай эгнээ гаргах, хурдны замын зогсоолын стандартыг боловсруулах, бусад чиглэлүүдийг холбох

боломжтой эцсийн зогсоолын зай талбайг шийдэх, нийтийн тээврийн зогсоолын гэрэлтүүлэг, цахим мэдээллийн самбар, дулаан зогсоолын халаалт зэргийг ажиллуулахад шаардагдах цахилгааны эх үүсвэр, дэд бүтцийг шийдвэрлүүлэх саналуудыг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/02/3040 тоот албан бичгээр хүргүүлсэн.

## ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1.Даргын зөвлөлийн хурлаас уг арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнг Тээврийн бодлого, судалгааны хэлтсийн удирдлагад хүргүүлэх

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтсийн дарга, албан хаагчид Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжтэй уялдаа холбоогоо сайжруулах, зогсоолын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид арга хэмжээг эрчимжүүлж, Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БЯМБАСҮРЭН

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн......
дугаар албан бичгийн 3 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН 39 ДҮГЭЭР ТОГТООЛ
МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 10 Улаанбаатар хот

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: УЛААНБААТАР ХОТ БА ДАГУУЛ ХОТ БҮЛГИЙН ХҮРЭЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 6. УЛААНБААТАР ХОТЫН ТҮГЖРЭЛ, АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛНА.** 6.1. Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна. 6.1.1. Авто замын ачааллыг бууруулах эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 6.1.1.1 | АХ-9.3.1, МУХТЖҮЧ-9.3.4, ЗГҮАХ-3.6.2 | Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, нийтийн тээврийн салбарыг бие даасан болгох | 2024 | НЗДТГ | - | - | - | Арга хэмжээний хэрэгжилт, хувь, 100 | - | - | Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар батлагдсан.<br>2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 03 дугаар тогтоолоор "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам" батлагдсан.<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 79 дүгээр тогтоолоор батлагдсан "Машин цагийн зардлын тариф"-ыг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 26 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдаж нийтийн тээврийн салбарын жолооч нарын сарын цалин 3,5 сая төгрөг, инженер техникийн ажилчдын цалин 3,0 сая төгрөг болж тус тус | 80 |

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэг-жих хуга-цаа | Үндсэн хэрэгжүү-лэх байгуул-лага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | нэмэгдсэн бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.<br>Нийтийн тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн удирдах ажилтнуудын 2024 оны 05 дугаар сарын шуурхай зөвлөгөөн дээр нийтийн тээврийн хэрэгслээр бэлэн мөнгө төлж зорчсон иргэдийн төлбөрийг нэгтгэн төвлөрүүлэх, хуваарилах үүрэг өгөгдсөн.<br>Үүний дагуу бэлэн мөнгөний орлогыг төвлөрүүлэх, хуваарилах заавры Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. Тус газрын дансанд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудаас 05-10 дугаар сарын хугацаанд нийт 1,348.4 сая төгрөг төвлөрч, хуваарилахаар ажиллаж байна.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийтийн тээврийн салбарт 2009 онд нийлүүлэгдсэн DAEWOO BS-106 маркийн автобусаар парк шинэчлэл хийгдсэн Эрдэм транс" ХХК, "Сутайн буянт "ХХК, "Мяралзаа " ХХК, "Автобус нэгдэл" ХХК-иудаас автобусны эргэн төлөлтийн үлдэгдлийг график гарган төлбөрийг эргүүлэн төлөх хуваарь гаргуулан 2024 онд улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн автобусыг түрээсээр эзэмшүүлсэн. Эргэн төлөлтийн хуваарийн дагуу нийтийн тээврийг хөгжүүлэх сан руу Эрдэм транс ХХК 161.4 сая төгрөг, Сутайн буянт ХХК 239.1 сая төгрөг, Автобус нэгдэл ХХК 20.0 сая төгрөг, нийт 420.5 сая төгрөгийг шилжүүлсэн байна. | |

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | 2024 оны 03-10 дугаар сарын аж ахуйн нэгж байгууллагуудад олгох санхүүжилтээс нийт 24,102.8 сая төгрөг суутгаж, 20,745.1 сая төгрөгийг нийтийн тээврийг хөгжүүлэх санд шилжүүлсэн. 10 дугаар сарын машин цагийн зардлын орлого зардлын зөрүү санхүүжилтийн төсөв хүрэлцээгүйгээс 3,357.7 сая төгрөгийг шилжүүлээгүй болно. Мөн 03-10 дугаар сарын аж ахуйн нэгж байгууллагуудад олгох санхүүжилтээс 1,869.1 сая төгрөг суутгаж, 1,629.2 сая төгрөгийг Улаанбаатар хөгжлийн корпораци ХК-д шилжүүлж төсөв хүрэлцээгүйгээс 239.9 сая төгрөгийг шилжүүлээгүй болно. | |
| 6.1.1.3 | АХ-9.3.12, МУХТЖҮЧ-9.2.4, ЗГҮАХ-6.1.6 | 6.1.1.3.Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох | 2024 | НЗДТГ | | | | Хүлээлтийн хугацааны бууралт, хувь, 25 | - | - | Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний 126 чиглэлд ажлын өдөр 1128, амралтын өдөр 924 тээврийн хэрэгсэл, 1170 автобусны зогсоолыг дайран өнгөрч өдөрт 450-500 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлж байна. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны 2023 оны 02 дугаар зөвлөмжийн дагуу чиглэлийн дахин төлөвлөлтийг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлэн ажилласан. Дахин төлөвлөлтийн хүрээнд иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс хуучин 71 чиглэлийг сэргээсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/630 дугаар захирамжийн дагуу төр захиргааны байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийг жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 07:00-16:00 цаг байхаар | 100 |

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | тогтоосонтой уялдуулан 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс нийтийн тээврийн 36 чиглэлийн автобусны цагийн хуваарьт өөрчлөлтийг оруулж, өглөөний эх авалтыг 05:20-05:40 цаг болгосон. Цагийн өөрчлөлт оруулахаас өмнө хоногт 16484:27:00 цаг ажиллах даалгавартай байсан нь 16661:54:00 болж 177:27:00 цагаар нэмэгдсэн.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/630 дугаар захирамжаар Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах зорилгоор нийслэлийн төр захиргааны байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийг 09 дүгээр сарын 01-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ны өдрийг хүртэлх хугацаанд 08:00-17:00 цаг байхаар тогтоосон тул 28 чиглэлийн эх авах цагт өөрчлөлт оруулж өглөөний эх авах цагийг 06:10-06:20 цаг болгон өөрчлөлт оруулсан.<br>Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, хүлээгдлийн хугацааг багасгах, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар чиглэлийн дахин төлөвлөлтийг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 74 чиглэлийн замналыг шинээр нээсэн. Мөн хот орчмын 21 чиглэл, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан үндсэн 7 чиглэл, дунд оврын 10 чиглэлийг шинээр нээж, 42 чиглэлийн замнал хааж, 25 чиглэлийн замналд зогсоол нэмж, 6 чиглэлийн замналаас зогсоол хасаж, 23 чиглэлийн замналд зогсоолын нэршил | |

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэг-жих хуга-цаа | Үндсэн хэрэгжүү-лэх байгуул-лага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | өөрчилж, 31 чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан. | |
| 6.1. Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.<br>6.1.3. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 6.1.3.1 | АХ-9.3.16, МУХТЖҮЧ-9.3.4, ЗГҮАХ-6.1.5 | Автобусны богино эргэлтийн терминал байгуулах /Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрд/ | 2024 | НЗДТГ | Орон нутгийн төсөв | | | Терминал, тоо, 3 | 8,000.0 | - | "Автобусны богино эргэлтийн терминалыг Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрдийн орчимд байгуулах" талаар тусгасан байдаг. Дээрх заалтын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зурагт нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна. Мөн 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах" тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон. | 30 |
| 6.1.3.5 | АХ-9.3.24, МУХТЖҮЧ-8.1.3, ЗГҮАХ-3.6.1 | Цахилгаан болон хийн автобусаар парк | 2024 | НЗДТГ | Улсын төсөв | | | Автобус, тоо, 73 | 45,779.90 | - | 2023 онд 35 ширхэг, 2024 онд 565 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй Yutong маркийн их багтаамжийн автобус, 31 ширхэг дизель | 100 |

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | шинэчлэлт хийх | | | | | | | | | евро-5 хөдөлгүүртэй угсраа автобусаар буюу нийт 631 автобусаар парк шинэчлэлт хийсэн. Нийтийн тээврийн үйлчилгээнд дизель евро-5 хөдөлгүүртэй, их багтаамжийн 631 автобусаар парк шинэчлэлт хийсэнтэй холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит 3 байгууллага 235 автобусаар 13 чиглэлд, хувийн хэвшлийн 10 аж ахуйн нэгж байгууллага 365 автобусаар 14 чиглэлд, их багтаамжийн угсраа 31 автобусаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит 2 байгууллага 3 чиглэлд үйлчилгээ үзүүлэх төлөвлөлтийг боловсруулж нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан өдөрт үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог 1220 болгон нэмэгдүүлсэн. | |
| 6.1.3.6 | АХ-9.3.24, МУХТЖҮЧ-8.1.3, ЗГҮАХ-3.6.3 | Цахилгаан автобус цэнэглэх өндөр хүчин чадалтай станц барих | 2024 | НЗДТГ | Орон нутгийн төсөв | | 11 | Шинээр байгуулагдсан станц, тоо, 36 | 5,000.0 | - | Нийслэлийн Засаг даргын 2023 оны захирамжаар НХААГ/20240101154 Цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж (Улаанбаатар) орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 250,000 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендерийг (www.tender.gov.mn) зарлаж 2024 оны 03 дугаар сарын 26-ний өдөр Азсеть ХХК 223,791 сая төгрөгөөр 1,250,000 төгрөгийн баталгаа гарган тендерт шалгарсан.<br>БММЗ эцэс автобусны буудлын эцэст 6 цэнэглэх төхөөрөмж байршуулах хүчин чадалтай ажлын гүйцэтгэл дууссан. "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, хүлээн авах комисс томилох тушаалд санал аван ажиллаж байна. | 100 |

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэг-жих хуга-цаа | Үндсэн хэрэгжүү-лэх байгуул-лага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж суурилуулах ажлын хүрээнд Морингийн давaанд байрлах "Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ-ын байранд "Алтайн үндэс констракшн" ХХК 2 ширхэг ХТП, 1 ширхэг РП дэд өртөө болох цахилгааны дэд төвийн угсралтын ажил гүйцэтгэх шатанд явагдаж байна.<br>Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 03 дугаар сарын 12-ний өдөр тендер зарлаж Ассеть ХХК шалгарсан бөгөөд Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-т 13 ширхэг, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т 1 ширхэг цэнэглэх төхөөрөмж тус тус суурилуулсан. | |
| Хэрэгжилтийн дундаж хувь/100%*3+80%*1+30%*1/ | | | | | | | | | | | | 82 |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА — З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — Ц.БЯМБАСҮРЭН

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн .......
дугаар албан бичгийн 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 10 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Бодлогын баримт бичгийн хүрээнд Нийтийн тээврийн бодлогын газраас 5 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн байна.

Хэрэгжилтийн дундаж 82 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна. Үүнээс 3 арга хэмжээ 100 хувь буюу “Үр дүнтэй”, 1 арга хэмжээ 80 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”, 1 арга хэмжээ 30 хувь буюу “Үр дүнгүй” байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 6.1.3.1. “Автобусны богино эргэлтийн терминал байгуулах /Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрд/” гэсэн арга хэмжээний хэрэгжилт 30 хувь буюу “Үр дүнгүй” байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр (зорилт арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй) байна.

“Автобусны богино эргэлтийн терминал байгуулах /Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрд/” гэсэн арга хэмжээний хүрээнд “Автобусны богино эргэлтийн терминалыг Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрдийн орчимд байгуулах” талаар тусгасан байдаг. Дээрх заалтын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зурагт нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна.

Мөн 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж “Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах” тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 6.1.1.1."Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, нийтийн тээврийн салбарыг бие даасан болгох" арга хэмжээний дагуу хийсэн ажил нь тогтолцоог оновчтой болгох чиглэлээр хийсэн ажлаа оновчтой тайлагнаагүй байна. /Хэрэгжилт 80 хувь/

## ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1.Тус арга хэмжээний бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан болович зохион байгуулалт, төсөв санхүүгийн асуудал шийдэгдээгүй байна.

2.2.Даргын зөвлөлийн хурлаас уг арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнг, Санхүү, аж ахуйн хэлтэс, Тээврийн бодлого, судалгааны хэлтсийн удирдлага, хариуцсан албан хаагчид хүргүүлэх

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтсийн дарга, албан хаагчид 2025 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгах саналаа өгөх, тус арга хэмжээний шаардагдах төсөв, зорилтот түвшингээ зөв тодорхойлох, хамтран хэрэгжүүлэх холбогдох байгууллагуудтайгаа уялдаа холбоогоо сайжруулах, Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид арга хэмжээг эрчимжүүлж, Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ХТҮ6986 9024050915 2117428

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БЯМБАСҮРЭН

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн......
дугаар албан бичгийн ..3.. дугаар хавсралт

XTY6987 9024060917 2117428

# "АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

/2024 оны жилийн эцсийн байдлаар/

2024 оны 12 дугаар сарын 10 — Улаанбаатар хот

| Д/д | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он) | Хүрсэн түвшин, үр дүн (2024 он) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | | | | |
| 1. | 9.2.13. Авто тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн, агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг шат дараатай, системтэй хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулна. | 2021-2030 | | | Техникийн хяналтын үзлэгийн төв нь Газрын даргын 2024 оны A/37 дугаар "Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай" тушаалаар, 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 05 дугээр сарын 24-ний өдрийг хүртэл зохион байгуулж 1116 тээврийн хэрэгсэл хамрагдсанаас 20 тээврийн хэрэгсэл тэнцээгүй, Газрын даргын 2024 оны A/105 дугаар "Намрын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай" 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл зохион байгуулагдаж, 1288 тээврийн хэрэгсэл хамрагдаж, 48 тээврийн буюу нийт 68 тээврийн хэрэгсэл нь утааны хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээ 1,2 коэффициент байхаас стандарт хэмжээнээс их байсан. Эдгээр тээврийн хэрэгслүүд нь хөдөлгүүр болон холбогдох эд ангийн засвар үйлчилгээ хийж, утааны хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээнд хүрч, давтан үзлэгээр тэнцсэн.<br>Нийтийн тээврийн үйлчилгээнд дизель евро-5 хөдөлгүүртэй, их багтаамжийн 631 автобусаар парк шинэчлэлт хийсэнтэй холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит 3 байгууллага 235 автобусаар 13 чиглэлд, хувийн хэвшлийн 10 аж ахуйн нэгж байгууллага 365 автобусаар 14 чиглэлд, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дизель евро-5 хөдөлгүүртэй, их багтаамжийн угсраа 31 | 100 |

| Д/д | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Зарцуул-сан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он) | Хүрсэн түвшин, үр дүн (2024 он) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | автобусаар орон нутгийн өмчит 2 байгууллага 3 чиглэлд үйлчилгээ үзүүлэх төлөвлөлтийг боловсруулж, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан өдөрт үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог 1220 болгон нэмэгдүүлсэн. Дээрх 631 автобус нь евро-5 хөдөлгүүртэй хүхэрлэг хий агаарт маш бага ялгаруулдаг байна. | |
| 2. | 9.3.12. Олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийг хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2021-2030 | | | 1.Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн газар, шороо, барилга угсралтын ажил Сонгино Хайрхан дүүргээс Хан-Уул дүүрэг Яармагийн эцсийн зогсоол хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна.<br>2.Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх "Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар" 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг хэлэлцүүлэгт Far East BRT Planning Co Limited. Компани нийтийн тээврийн тусгай замын автобус зорчих төлөвлөсөн трассын талаар танилцуулсан ба Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Урьдчилсан байдлаар Ард-Аюушийн өргөн чөлөө, Их тойруу, Сүхбаатар талбай хүртэлх трассыг хийх ба 2025 оны 01 дүгээр сард загвар зураглалыг бэлэн болгож, 2025 оны 04 дүгээр сард нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтын ажлыг хийхээр төлөвлөсөн.<br>3.2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар | 70 |

| Д/д | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он) | Хүрсэн түвшин, үр дүн (2024 он) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигтэй танилцаж, хуралдсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро барих төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан. 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, "Духуа Инженеринг" ХК ба түншлэл нь Улаанбаатар метро төслийн хүний нөөц бэлтгэх чиглэлд хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд метро жолоодлого, удирдлага, механик инженер, метроны цахилгаан, дохиолол, барилгын инженер гэсэн 4 чиглэлд сургалтын хөтөлбөрийг зөвлөх баг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус хөтөлбөртэй Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн холбогдох мэргэжилтнүүд танилцан, саналыг хүргүүлсэн. Одоогоор хамтарсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон хамтран ажиллах Бүгд Найрамдах Солонгос Улсын их сургуулийг тодорхойлох судалгаа, уулзалтууд хийгдсэн. | |
| 3. | 9.3.19. Авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, авто үйлчилгээний салбарт баталгаат үйлчилгээний тогтолцоог сайжруулна. | 2021-2030 | | | Авто үйлчилгээний салбарт баталгаат үйлчилгээний тогтолцоог бий болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад "Автомашины оношилгоо болон засвар" үйлчилгээ тусгагдсан.<br>Авто үйлчилгээ эрхлэгчид нь "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай" хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалт, MNS ISO/IEC17065:2013 стандартын шаардлагыг хангасан байгууллагын тохирлын үнэлгээнд хамрагдан, ангилал тогтоолгон үйл ажиллагаа явуулна.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/112 тушаал "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам"-ын хэрэгжилтийг ханган онлайн бизнес төв, биетээр болон цахимаар хүсэлтийг хүлээн авч 2024 оны байдлаар 92 иргэн, 52 аж ахуйн нэгж, | 100 |

| Д/д | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он) | Хүрсэн түвшин, үр дүн (2024 он) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагын нийт 144 буюу 400 ажил үйлчилгээнд ангилал тогтоож, гэрээ байгуулан ажилласан. | |
| 4. | 9.3.21. Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлнэ. | 2021-2030 | | | Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний 126 чиглэлд ажлын өдөр 1128, амралтын өдөр 924 тээврийн хэрэгсэл, 1170 автобусны зогсоолыг дайран өнгөрч өдөрт 450-500 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлж байна. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны 2023 оны 02 дугаар зөвлөмжийн дагуу чиглэлийн дахин төлөвлөлтийг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлэн ажилласан. Дахин төлөвлөлтийн хүрээнд иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс хуучин 71 чиглэлийг сэргээсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/630 дугаар захирамжийн дагуу төр захиргааны байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийг жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 07:00-16:00 цаг байхаар тогтоосонтой уялдуулан 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс нийтийн тээврийн 36 чиглэлийн автобусны цагийн хуваарьт өөрчлөлтийг оруулж, өглөөний эх авалтыг 05:20-05:40 цаг болгосон. Цагийн өөрчлөлт оруулахаас өмнө хоногт 16484:27:00 цаг ажиллах даалгавартай байсан нь 16661:54:00 болж 177:27:00 цагаар нэмэгдсэн.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/630 дугаар захирамжаар Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах зорилгоор нийслэлийн төр захиргааны байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийг 09 дүгээр сарын 01-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ны өдрийг хүртэлх хугацаанд 08:00-17:00 цаг байхаар тогтоосон тул 28 чиглэлийн эх авах цагт өөрчлөлт оруулж өглөөний эх авах цагийг 06:10-06:20 цаг болгон өөрчлөлт оруулсан.<br>Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, хүлээгдлийн хугацааг багасгах, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар чиглэлийн дахин төлөвлөлтийг | 100 |

| Д/д | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он) | Хүрсэн түвшин, үр дүн (2024 он) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 74 чиглэлийн замналыг шинээр нээсэн. Мөн хот орчмын 21 чиглэл, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан үндсэн 7 чиглэл, дунд оврын 10 чиглэлийг шинээр нээж, 42 чиглэлийн замнал хааж, 25 чиглэлийн замналд зогсоол нэмж, 6 чиглэлийн замналаас зогсоол хасаж, 23 чиглэлийн замналд зогсоолын нэршил өөрчилж, 31 чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан. | |
| 5. | 9.3.22. Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх терминал болон зогсоолуудыг нэгдсэн уялдаатайгаар барьж байгуулна. | 2021-2030 | | | Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.3.1 дэх заалтад "Автобусны богино эргэлтийн терминалыг Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрдийн орчимд байгуулах" талаар тусгасан байдаг. Дээрх заалтын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зурагт нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна.<br>Мөн 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах" тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан болович газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон. | 30 |
| 6. | 9.3.23. Сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. | 2021-2030 | | | Нийслэлийн Боловсролын газраас ирүүлсэн саналын дагуу 70 сургуулийн 71 чиглэлд 72 автобусаар үйлчилгээ хүргэхээр тус газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/84 дүгээр тушаал батлагдсан. Үүнд: Зорчигч тээврийн нэгтгэл-7 чиглэлд 7 автобус, Зорчигч тээвэр гурав- 5 чиглэлд 5 автобус, Чингэлтэй дүүрэг- 6 чиглэлд 7 автобус, Сүхбаатар дүүрэг- 7 чиглэлд 7 автобус, Хан-Уул дүүрэг- 8 чиглэлд 8 автобус, Баянзүрх дүүрэг- 10 чиглэлд 10 автобус, Баянгол- | 100 |

| Д/д | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он) | Хүрсэн түвшин, үр дүн (2024 он) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүүрэг 7 чиглэлд 7 автобус, Сонгинохайрхан- дүүрэг 16 чиглэлд 16 автобус, Налайх дүүрэг-2 чиглэлд 2 автобус, Багануур дүүрэг- 2 чиглэлд 2 автобус, Багахангай дүүрэг-1 чиглэлд 1 автобусаар үйлчилгээ үзүүлэх төлөвлөлтийг боловсруулж үйлчилгээг хүргэсэн.<br>Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны А/99 дүгээр тушаалын дагуу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс "Хүүхдийн сургуулийн автобус"-ыг мэргэжлийн чиг үүргийн байгууллага болох автобус баазад шилжүүлэх үүргийн дагуу Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдийн өмчлөлд байсан Dongfeng EQ6100ST6D1 загварын 57 автобусыг нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>• Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ-7<br>• Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ -11<br>• Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ -4<br>• Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ -8<br>• Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ -27 хүүхдийн автобусыг хүлээлцүүлсэн.<br>2024-2025 оны хичээлийн жилд Нийслэлийн боловсролын газраас 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 6/1495 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналын дагуу тус газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/100 дугаартай тушаалаар 7 чиглэлийн замналыг шинэчлэн баталсан бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс ерөнхий боловсролын 70 сургуулийн 67 чиглэлд 72 автобусаар үйлчилгээг эхлүүлж,<br>2024 оны 01 дүгээр сараас 10 дугаар сард давхардсан тоогоор 83 сургуулийн 69 чиглэлд 69 сургуулийн хүүхдийн автобусаар 1057560 хүүхэд тээвэрлэсэн байна. | |

| Д/д | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он) | Хүрсэн түвшин, үр дүн (2024 он) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 7. | 9.3.24. Тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн эх үүсвэрээр цэнэглэх сүлжээг байгуулна. | 2021-2030 | | | Нийслэлийн Засаг даргын 2023 оны захирамжаар НХААГ/20240101154 Цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж (Улаанбаатар) орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 250,000 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендерийг (www.tender.gov.mn) зарлаж 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Азсеть ХХК 223,791 сая төгрөгөөр 1,250,000 төгрөгийн баталгаа гарган тендерт шалгарсан.<br>БММЗ эцэс автобусны буудлын эцэст 6 цэнэглэх төхөөрөмж байршуулах хүчин чадалтай ажлын гүйцэтгэл дууссан. "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, хүлээн авах комисс томилох тушаалд санал аван ажиллаж байна. Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж суурилуулах ажлын хүрээнд Морингийн давааанд байрлах "Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ-ын байранд "Алтайн үндэс констракшн" ХХК 2 ширхэг ХТП, 1 ширхэг РП дэд өртөө болох цахилгааны дэд төвийн угсралтын ажил гүйцэтгэх шатанд явагдаж байна.<br>Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 03 дугаар сарын 12-ний өдөр тендер зарлаж Азсеть ХХК шалгарсан бөгөөд Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-т 13 ширхэг, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т 1 ширхэг цэнэглэх төхөөрөмж тус тус суурилуулсан. | 100 |
| 8. | 9.3.25. Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлнэ. | 2021-2030 | | | Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна. Төслийн нэгжээс нийтийн тээврийн удирдлагын төвийн ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг дахин зарлахаар бэлтгэсэн бөгөөд тус газраас ажлын даалгаварт тусгах саналыг хүргүүлж, төслийн нэгжээс ажлын даалгаврыг шинэчилж, өөрчлөлт оруулсан ажлын даалгавар болон сонирхлоо илэрхийлэх хүсэлтийн зарлалыг Дэлхийн банкаар хянуулахаар 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хүргүүлсэн байна. | 100 |

| Д/д | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он) | Хүрсэн түвшин, үр дүн (2024 он) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тус газрын удирдлагын төвийг бүрэн шинэчилж удирдлага, мэдээллийн дэлгэцийг байршуулан нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна.<br>Нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн менежментийн системийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд автобуснуудад зорчигч тоолох систем, онлайн камер 1017 ширхгийг суурилуулсан. | |
| Дундаж хувь: 100%*6+70%*1+30%*1 | | | | | | 87.5 |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БЯМБАСҮРЭН

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ......
дугаар албан бичгийн 6 дугаар хавсралт

XTY6987 9024050917 2117428

# “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 10 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагаанд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хүрээнд тус газраас 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ба хэрэгжилтийн дундаж 87.5 хувь байна. Үүнээс 100 хувь буюу “Үр дүнтэй” 6 арга хэмжээ, 70 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” 1 арга хэмжээ, 30 хувь буюу “Үр дүнгүй” 1 арга хэмжээ байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 87.5 хувь байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр “Тодорхой үр дүнд хүрсэн” (зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай) үнэлгээтэй байна.

1.1.Бодлогын баримт бичгийн 9.3.2.“Олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийг хэрэглээнд нэвтрүүлнэ” гэсэн арга хэмжээ 70 хувийн биелэлттэй байгаа ба дараах 3 төслийн ажлууд хийгдэж байна. Үүнд:

1.Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн тээврийн шугам байгуулах ажил Хан-Уул дүүргийн Яармагийн эцсийн зогсоолоос Сонгино Хайрхан дүүрэг хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна.

2.Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх “Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар” 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг семинарт Far East BRT Planning Co Limited Компани нийтийн тээврийн тусгай замын автобус зорчих трассын талаар танилцуулсан ба Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн

чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Урьдчилсан байдлаар Ард-Аюушийн өргөн чөлөө, Их тойруу, Сүхбаатар талбай хүртэлх трассыг хийх ба 2025 оны 01 дүгээр сард загвар зураглалыг бэлэн болгож, 2025 оны 04 дүгээр сард нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтын ажлыг хийхээр төлөвлөсөн.

3.2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигтэй танилцаж, хуралдсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро барих төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан. 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Духуа Инженеринг ХК ба түншлэл нь Улаанбаатар метро төслийн хүний нөөц бэлтгэх чиглэлд хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд метро жолоодлого, удирдлага, механик инженер, метроны цахилгаан, дохиолол, барилгын инженер гэсэн 4 чиглэлд сургалтын хөтөлбөрийг зөвлөх баг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус хөтөлбөртэй Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн холбогдох мэргэжилтнүүд танилцан, саналыг хүргүүлсэн. Одоогоор хамтарсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон хамтран ажиллах Бүгд Найрамдах Солонгос Улсын их сургуулийг тодорхойлох судалгаа, уулзалтууд хийгдсэн.

1.2.Бодлогын баримт бичгийн 9.3.22."Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх терминал болон зогсоолуудыг нэгдсэн уялдаатайгаар барьж байгуулна" гэсэн арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зурагт нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна.

Мөн 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж “Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах” тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.

## ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1.Даргын зөвлөлийн хурлаас уг арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнг Тээврийн бодлого, судалгааны хэлтсийн удирдлагад хүргүүлэх

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтсийн дарга, албан хаагчид 2025 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээрх 3 арга хэмжээг тусгах саналаа өгөх, тус арга хэмжээний шаардагдах төсөв, зорилтот түвшингээ зөв тодорхойлох, хамтран хэрэгжүүлэх холбогдох байгууллагуудтай уялдаа холбоогоо сайжруулах, Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид арга хэмжээг эрчимжүүлж, Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БЯМБАСҮРЭН

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ...
дугаар албан бичгийн 7 дугаар хавсралт

# НИЙСЛЭЛ ХОТЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 2021-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугээр сарын 11 | Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэтгэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | | | | | |
| Зорилго 9. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ. | | | | | | | |
| 1 | 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ. | 9.21.1 Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. | - | - | Нийслэлийн төсөвт нийтийн тээврийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах төсөв тусгагдаагүй тул Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжийн Төлөөлөн удирдах хорооны хурлаар хэлэлцүүлэн, Нийтийн тээврийн салбарын Мастер төлөвлөгөөг гүйцэтгүүлэх чиглэлээр шийдвэр гаргуулан хамтран ажиллаж байна. ТЭЗҮ-г боловсруулах ажлын хүрээнд Их Британид төвтэй Royal Haskoning DHV компаниас олон улсын нийтийн тээврийн шинжээчийн баг ирсэн бөгөөд 3 удаагийн уулзалт зохион байгуулан мэдээлэл солилцон ажиллаж байна. Мөн Дэлхийн банкны суурин төлөөлөгч нарт Нийслэлийн Нийтийн тээврийн газраас мастер төлөвлөгөөнд тусгуулах 77 төрлийн саналыг боловсруулан хүргүүлэн ажилласан байна.<br>"Улаанбаатар хотын нийтийн тээврийн стратеги боловсруулах" ажлын хүрээнд Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид холбогдох саналыг хүргүүлж хамтран ажилласан бөгөөд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар AIRI-FEM түншлэл/Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн болон Far East BRT Planning Co.,Ltd нараас бүрдэх/ хамтарсан гэрээг 2024 оны 04 дүгээр сард байгуулагдсан. Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид нийт 5 удаагийн саналыг хүргүүлсэн.<br>Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, хүлээгдлийн хугацааг багасгах, нийтийн тээврийн | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэт-гэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар чиглэлийн дахин төлөвлөлтийг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 74 чиглэлийн замналыг шинээр нээсэн. Мөн хот орчмын 21 чиглэл, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан үндсэн 7 чиглэл, дунд оврын 10 чиглэлийг шинээр нээж, 42 чиглэлийн замнал хааж, 25 чиглэлийн замналд зогсоол нэмж, 6 чиглэлийн замналаас зогсоол хасаж, 23 чиглэлийн замналд зогсоолын нэршил өөрчилж, 31 чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан. | | |
| 2 | 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ. | 9.21.2. Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн сүлжээнд холбогдсон байна. | - | - | **2021 он:** Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн шинээр баригдах "Аэро сити" буюу дагуул хотын нийтийн тээврийн үйлчилгээний 4 чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан, батлуулсан.<br>Дээрх ажлын хүрээнд Хөшигийн хөндийн "Чингис хаан" олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орж, үйл ажиллагаа нь 2021 оны 07 сарын 04-ний өдрөөс эхэлсэн хэдий ч Ковид-19 цар тахалтай холбогдуулан үйл ажиллагааг түр зогсоосон байна.<br>**2022 он:** Улаанбаатар хотын хаяа дагуул 16 хот тосгодын 13 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 16 чиглэлд хүргэж, өдөр тутам 60 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлсэн.<br>**2023 он**: Улаанбаатар хотын хаяа дагуул 16 хот тосгодын 14 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 16 чиглэлд хүргэж, өдөр тутам 60 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Дагуул хот байгуулах байршил буюу Чингис хаан олон улсын нисэх буудалд 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 10-ны хүртэлх хугацаанд 586 зорчигч тээвэрлэсэн.<br>**2024 он:** Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 18 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 19 чиглэлд хүргэж, өдөр тутам 73 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. | 100 | - |
| 3 | 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой | 9.21.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг | | | 1.Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн газар, шороо, барилга угсралтын ажил Сонгино Хайрхан дүүргээс Хан-Уул дүүрэг Яармагийн эцсийн зогсоол хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна.<br>2.Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх | 70 | Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Шинэ бүтээн |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэтгэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ. | зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна. | | | "Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар" 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг хэлэлцүүлэгт Far East BRT Planning Co Limited компани нийтийн тээврийн тусгай замын автобус зорчих төлөвлөсөн трассын талаар танилцуулсан ба Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Урьдчилсан байдлаар Ард-Аюушийн өргөн чөлөө, Их тойруу, Сүхбаатар талбай хүртэлх трассыг хийх ба 2025 оны 01 дүгээр сард загвар зураглалыг бэлэн болгож, 2025 оны 04 дүгээр сард нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтын ажлыг хийхээр төлөвлөсөн.<br>3.2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигтэй танилцаж, хуралдсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро барих төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан. 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, "Духуа Инженеринг" ХК ба түншлэл нь Улаанбаатар метро төслийн хүний нөөц бэлтгэх чиглэлд хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд метро жолоодлого, удирдлага, механик инженер, метроны цахилгаан, дохиолол, барилгын инженер гэсэн 4 чиглэлд сургалтын хөтөлбөрийг зөвлөх баг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус хөтөлбөртэй Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн холбогдох мэргэжилтнүүд | | байгуулалт ХК хариуцан ажиллаж байна. |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэт-гэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | танилцан, саналыг хүргүүлсэн. Одоогоор хамтарсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон хамтран ажиллах Бүгд Найрамдах Солонгос Улсын их сургуулийг тодорхойлох судалгаа, уулзалтууд хийгдсэн. | | |
| 4 | 9.22. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн, нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоолтой болно. | 9.22.1 Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийсэн байна. | | | Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд:<br>**2021 онд 35 автобус:**<br>“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ нь Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 2021 оны 06 дугаар сард 35 их багтаамжийн автобус<br>**2022 онд 71 автобус:**<br>-10 ширхэг давхар автобус<br>-1 ширхэг их багтаамжийн цахилгаан автобус<br>-Xiamen golden dragon bus XML6105J15C загварын их багтаамжийн 60 ширхэг автобус<br>**2023 онд 364 автобус:**<br>-"Xiamen Golden Dragon Bus" ХХК-ийн их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 ширхэг автобус<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Тэнүүн огоо" ХХК-ийн хооронд 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ННТГ23001 тоот гэрээ дагуу 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй SKYWELL маркын автобус<br>-50 ширхэг дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй HYUNDAI COUNTY маркын автобус<br>-Yutong Bus Co.,Ltd-ийн үйлдвэрлэсэн их багтаамжийн дизель евро-5 хөдөлгүүртэй 35 ширхэг автобус<br>**2024 онд 596 автобус:**<br>- 2024 онд 565 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй Yutong маркийн их багтаамжийн автобус, 31 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй угсраа автобусаар буюу нийт 596 автобусаар парк шинэчлэлт хийсэн.<br>Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор “Нийслэлийн Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажил”-ын хүрээнд 2021-2024 онд евро-5 /дизель/ маркийн 965 автобус, цахилгаан хөдөлгүүртэй 101 автобусаар нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан үйлчилгээнд ажиллах | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэт-гэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | тээврийн хэрэгслийн тоог 1066 автобусаар нэмэгдүүлж ажилласан. | | |
| 5 | | 9.22.2 Цахилгаан тээврийн хэрэгслийг цахилгаан эх үүсвэрээр цэнэглэх цэгийг байгуулсан байна. | - | - | Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж суурилуулах ажлын хүрээнд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 1 сарын хугацаатай тендер зарлаж, Азсеть ХХК шалгарсан бөгөөд Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-т 12 ширхэг суурилуулснаас тус баазад-10 ширхэг, 20 дугаар хорооны Сэлбийн эцсийн буудалд-1 ширхэг, Дарь – Эхийн тоосгоны үйлдвэрийн эцсийн автобусны зогсоолд-1 ширхэг, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т 1 ширхэг нийт 13 цэнэглэх төхөөрөмж тус тус суурилуулсан байна. | 100 | - |
| 6 | | 9.22.3 Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулна. | - | - | 1.УИХ-ын гишүүн Ц.Мөнх-оргилын санаачилгаар Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хороонд байрлах 2 эцсийн зогсоолыг тохижуулах ажлыг "Үүлэн сүндэр" ХХК нь гүйцэтгэж, иж бүрэн тохижуулах Бэлхийн эцэс, Тоосгоны эцсийн хүлээлгийн дулаан 2 зогсоолын ажил болон чиглэлийн тээврийн хэрэгслийн 15 дундын зогсоолын ажил бүрэн хийгдэж, гүйцэтгэл 100 хувьтай байна.<br>2.УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар гишүүний санаачилгаар Зам, тээврийн сайдын багцаар Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянгын авто замд чиглэлийн тээврийн хэрэгслийн 19 зогсоолыг тохижуулахаар "Цагаан толгойн нуур" ХХК шалгарч 6 зогсоолын ажлыг хийж дууссан ба ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна.<br>3.Ерөнхий менежерийн 2023 оны А/45 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж нийтийн бие засах газар болон барилга байгууламжтай 6 эцсийн зогсоол, нийтийн тээврийн үйлчилгээний тохижилт хийгдсэн зогсоолуудын арчлалт ашиглалтыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэн аж ахуй нэгжид хариуцуулахаар тендер зарлан сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж Дижитал концефт ХХК (GS-25)-нд Нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн зогсоолыг засварлаж тохижуулах, ашиглалтыг хариуцуулахаар шийдвэрлэн 5 зогсоолыг хүлээлгэн өгсөн. | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэтгэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | 4.2024 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2,5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулсан.<br>Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол шинээр барих, шинэчлэх ажлын хүрээнд шинээр хийхээр төлөвлөж буй сүүдрэвч болон үйлчилгээтэй дулаан танхим хосолсон зогсоолын 12 байгууламжийн байршлыг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01/02/814, 13 байгууламжийн байршлыг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/02/2706 дугаартай албан бичгээр тус тус Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд болон гүйцэтгэгч Тэгш Хүслийн Гэрэл ХХК-нд хүргүүлсэн. | | |
| 7 | 9.23. Улаанбаатар хотод ачаа тээврийн логистик, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулна. | 9.23.1 Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна. | - | - | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/311 дугаар захирамжаар "Нийслэлийн зүүн хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн төв" байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгчээр "Туушин" ХХК, нийслэлийн хүлээсэн эрх, үүргийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/02 дугаартай хамтран ажиллах гэрээгээр "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК хариуцан ажиллаж байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/131 захирамжаар батлагдсан Улаанбаатар хотын зүүн хэсэгт ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах ажлын хэсгийг хурал 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр болсон. Уг хуралдаанд Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо, тээвэр зуучийн терминал эзэмшин үйлчилгээ явуулдаг 11 байгууллага, төрийн холбогдох байгууллагуудыг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулагдаж мэдээлэл авч ажилласан.<br>"Олон улсын худалдаа логистикийн төв" ХК нь Баруун ачааны логистик "Төмөр замын гаалийн хяналтын бүс", "Хангарди Терминал" "Зорчигч тээврийн Автовокзал терминал" зэрэг төслүүдийг хэрэгжүүлж байна.<br>-Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.3.1 дэх заалтад "Автобусны богино эргэлтийн терминалыг Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрдийн орчимд байгуулах" талаар тусгасан байдаг. Дээрх заалтын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 | 30 | "Нийслэлийн зүүн хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн төв" байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгчээр "Туушин" ХХК, хамтран ажиллах гэрээгээр "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК хариуцан ажиллаж байна.<br><br>Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах газрын |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэт-гэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | дүгээр хороо, 32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зурагт нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна.<br>Мөн 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах" тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон. | | асуудал шийдэгдээгүй тул санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацааг дуусгавар болгосон. |
| | Хэрэгжилтийн дундаж хувь /100%*5+70%*1+30%*1/ | | | | | 85.71 | |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ц.ОДМАНДАХ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ...
дугаар албан бичгийн ...... дугаар хавсралт

# НИЙСЛЭЛ ХОТЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 2021-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугээр сарын 11 — Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагд-сан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэ-лийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | | | | | | | | | | | |
| Зорилго 9. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтэцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ. | | | | | | | | | | | | | |
| 1 | 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ. | 9.21.1 Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. | Нийтийн тээврийн чиглэлийн давхцал буурах хувь | Хувь | 2020 | 0 | 2024 | 30 | - | - | Нийтийн тээврийн чиглэлийн дахин төлөвлөлтөөр үндсэн 6 гол гудамж замаар 375, тойрог 8 чиглэлд 74, бусад гудамж замаар дайран өнгөрөх 40 чиглэлд 494, хот орчмын 15 чиглэлд 87 автобусаар үйлчилгээнд ажиллахаар төлөвлөсөн боловч иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу 4 чиглэлийн маршрутад өөрчлөлт оруулан, 71 чиглэл маршрутыг эргэн сэргээсэн. Чиглэлийн давхцалын судалгааг нийтийн тээврийн үйлчилгээний 111 чиглэлийн дайран өнгөрөх 1170 зогсоолоос 70 хувиас дээш давхцалтай 12 чиглэлийг харьцуулан шинжилж, 2 чиглэлийн давхцалыг арилгасан Нийтийн тээврийн чиглэлийн давхцал 11 хувь буурсан байна. | 70 | Иргэдээс шинэ төлөвлөлттэй холбоотой санал, хүсэлт, гомдол ихээр ирүүлж байгаатай холбоотой. |
| 2 | | 9.21.2. Зорчигч | Холбогдсон дагуул, | Тоо | 2020 | 11 | 2024 | 14 | - | - | Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 18 суурьшилд нийтийн | 100 | ЗТХСайдын 2023 оны 12 |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагд-сан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэ-лийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн сүлжээнд холбогдсон байна. | хаяа, хот, тосгод | | | | | | | | тээврийн үйлчилгээг 19 чиглэлд хүргэж, өдөр тутам 73 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. | | дугаар сарын 05-ны өдрийн Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай А/306 дугаартай тушаалаар Хот хоорондын нийтийн тээврийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээнд тээвэрлэлтийн чиглэл, зураглалыг тусган, хэрэгжүүлэх ажлыг Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-т даалгасан. |
| 3 | | 9.21.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна. | "Агаарын дүүжин замын тээврийн төсөл"-ийн чиглэлийн урт | км | 2020 | 0 | 2024 | 10.1 | - | - | "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийн 2 дугаар шугамын төслийн газар, шороо, барилга угсралтын ажил Сонгино Хайрхан дүүргээс Хан-Уул дүүрэг Яармагийн эцсийн зогсоол хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна. | 70 | Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Шинэ бүтээн байгуулалт ХК хариуцан |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагд-сан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэ-лийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | | | ажиллаж байна. |
| 4 | 9.22. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн, нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоолтой болно. | 9.22.1 Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийсэн байна. | Байгаль орчинд ээлтэй автобус | Тоо | 2020 | 12 | 2024 | 570 | Нийслэ-лийн төсөв 61,625,4 Улсын төсөв 318,000.0 | Нийслэлийн төсөв 59,698,6 Улсын төсөв 134,561.3 | 2024 онд 565 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй Yutong маркийн их багтаамжийн автобус, 31 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй угсраа автобусаар буюу нийт 596 автобусаар парк шинэчлэлт хийсэн. | 100 | - |
| 5 | | 9.22.2 Цахилгаан тээврийн хэрэгслийг цахилгаан эх үүсвэрээр цэнэглэх цэгийг байгуулсан байна. | Цахилгаан автобус цэнэглэх цэг | Тоо | 2020 | 3 | 2024 | 8 | - | - | 4 байршилд 13 цэнэглэгчээр цахилгаан автобусыг цэнэглэж байна. | 100 | - |
| 7 | | 9.22.3 Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулна. | Шинээр баригдах нийтийн тээврийн зогсоол | Тоо | 2020 | 930 | 2024 | 960 | - | - | Нийслэлийн засаг даргын тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2.5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулсан. | 100 | - |
| 8 | | | Нийтийн тээврийн үйлчилгээ-ний зогсоолд байршуулах | Тоо | 2020 | 3 | 2024 | 153 | - | - | Нийтийн тээврийн хэрэгслийн 209 зогсоолын мэдээллийн самбарт дахин төлөвлөлтийн ерөнхий мэдээллийг байршуулснаас гадна иргэд, олон нийтэд мэдээллийг цахимаар хүргэх | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагд-сан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | зогсоолд байршуулах мэдээллийн самбар | | | | | | | | гадна иргэд, олон нийтэд мэдээллийг цахимаар хүргэх зорилгоор "Imap.mn" цахим сайт, апликейшнд дамжин суултын мэдээллийг байршуулсан. | | |
| 9 | | | Нийтийн тээврийн үйлчилгээ-ний тохижуулах зогсоол | Тоо | 2020 | 212 | 2024 | 250 | - | - | Нийслэлийн засаг даргын тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2.5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулсан. | 100 | - |
| 10 | 9.23. Улаанбаатар хотод ачаа тээврийн логистик, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулна. | 9.23.1 Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна. | Зорчигчдын ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал | Тоо | 2020 | 0 | 2024 | 2 | - | - | "Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах" тендерт Гео зураглал ХХК нь шалгарч гэрээ байгуулсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс болж Эдийн засгийн хөгжлийн яамны санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацааг дуусгавар болгосон. | 30 | Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах газрын асуудал шийдэгдээгүй тул санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацааг дуусгавар болсон. |
| Хэрэгжилтийн дундаж хувь:/100*6+70*2+30*1/ | | | | | | | | | | | | 85.5 | |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ц.ОДМАНДАХ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ........
дугаар албан бичгийн 9... дугаар хавсралт

# "НИЙСЛЭЛ ХОТЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН 2021-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 13 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу "Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө"-ний хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагаанд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хүрээнд тус газраас 7 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ба хэрэгжилтийн дундаж 85.7 хувь байна. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 85.7 хувь байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр "Тодорхой үр дүнд хүрсэн" (зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай) үнэлгээтэй байна.

Үүнээс 100 хувь буюу "Үр дүнтэй" 5 арга хэмжээ, 70 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" 1 арга хэмжээ, 30 хувь буюу "Үр дүнгүй" 1 арга хэмжээ байна.

1.1.Бодлогын баримт бичгийн 9.21.3."Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна" гэсэн арга хэмжээ 70 хувийн биелэлттэй байгаа ба дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

1.2.Бодлогын баримт бичгийн 9.23.3." Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна." гэсэн арга хэмжээ 30 хувийн биелэлттэй байгаа ба Нийслэл хотод ачаа тээврийн үйл ажиллагааг нийслэлийн гудамж замын ачааллаттай уялдуулан зөв, оновчтой хэлбэрээр зохион байгуулах ажлын хүрээнд:

1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/311 дугаар захирамжаар "Нийслэлийн зүүн хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн төв" байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгчээр "Туушин" ХХК, нийслэлийн хүлээсэн эрх, үүргийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/02 дугаартай хамтран ажиллах гэрээгээр "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК хариуцан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/131 захирамжаар батлагдсан Улаанбаатар хотын зүүн хэсэгт ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах ажлын хэсгийг хурал 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр болсон. Уг хуралдаанд Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо, тээвэр зуучийн терминал эзэмшин үйлчилгээ явуулдаг 11 байгууллага, төрийн холбогдох байгууллагуудыг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулагдаж мэдээлэл авч ажилласан.

2.Автобусны богино эргэлтийн терминалыг Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрдийн орчимд байгуулах ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо,

32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зурагт нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна.

Мөн 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж “Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах” тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.

## ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1.Даргын зөвлөлийн хурлаас уг арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнг Тээврийн бодлого, судалгааны хэлтэс, Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтсийн удирдлагад хүргүүлэх

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтсийн дарга, албан хаагчид 2025 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээрх 2 арга хэмжээг тусгах саналаа өгөх, тус арга хэмжээний шаардагдах төсөв, зорилтот түвшингээ зөв тодорхойлох, хамтран хэрэгжүүлэх холбогдох байгууллагуудтай уялдаа холбоогоо сайжруулах, Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид арга хэмжээг эрчимжүүлж, Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БЯМБАСҮРЭН

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ......
дугаар албан бичгийн 10 дугаар хавсралт

XTY6987 9024050917 2117428

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
/2020-2024 оны байдлаар/

2024 оны 12 дугээр сарын 11 — Улаанбаатар хот

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ЗУРГАА.НИЙСЛЭЛ БА БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | |
| 6.3 Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | |
| **356** | 6.3.13.1 | **Заалт:** Сурагчийн автобусны парк шинэчлэлт хийнэ. | **НЗДТГ** | **НТБГ** | 100 | |
| | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Моннис Моторс” ХХК-тай байгуулсан НЗДТГ-20/А-463-2-01 дүгээр гэрээний дагуу нийт 75 хүүхдийн сургуулийн автобус нийлүүлэхээс 2020 онд “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-т сургуулийн хүүхдийн 5 автобус, 2022 онд сургуулийн хүүхдийн 20 автобусыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т, 2023 оны 02 дугаар сард сургуулийн 50 автобус шинээр орж ирснээр 2020-2023 онд сургуулийн 75 автобус шинээр орж ирсэн.<br>Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд тээвэрлэх автобусны техникийн бүрэн байдлыг хангуулах, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд нийт 191 тээврийн хэрэгслээс 134 тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулаад байна. | | | | |
| **357** | 6.3.13.2. | **Заалт:** Сургуулийн сурагчид зориулсан тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулах | **НТБГ** | **НЗДТГ** | 100 | |
| | | 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн автобусны үйлчилгээнд өссөн дүнгээр нийт 58 тээврийн хэрэгсэл 58 чиглэлд 69 сургуулийн 1339493 хүүхэд тээвэрлэсэн байна.<br>Мөн онд Нийслэлийн Боловсролын газраас ирүүлсэн саналын дагуу 70 сургуулийн 71 чиглэлд 72 автобусаар үйлчилгээ хүргэхээр тус газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/84 дүгээр тушаал батлагдсан. Үүнд: Зорчигч тээврийн нэгтгэл-7 чиглэлд 7 автобус, Зорчигч тээвэр гурав- 5 чиглэлд 5 автобус, Чингэлтэй дүүрэг- 6 чиглэлд 7 автобус, Сүхбаатар | | | | |

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | дүүрэг- 7 чиглэлд 7 автобус, Хан-Уул дүүрэг- 8 чиглэлд 8 автобус, Баянзүрх дүүрэг- 10 чиглэлд 10 автобус, Баянгол- дүүрэг 7 чиглэлд 7 автобус, Сонгинохайрхан- дүүрэг 16 чиглэлд 16 автобус, Налайх дүүрэг-2 чиглэлд 2 автобус, Багануур дүүрэг- 2 чиглэлд 2 автобус, Багахангай дүүрэг- 1 чиглэлд 1 автобусаар үйлчилгээ үзүүлэх төлөвлөлтийг боловсруулж үйлчилгээг хүргэсэн.<br>Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны А/99 дүгээр тушаалын дагуу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс "Хүүхдийн сургуулийн автобус"-ыг мэргэжлийн чиг үүргийн байгууллага болох автобус баазад шилжүүлэх үүргийн дагуу Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдийн өмчлөлд байсан Dongfeng EQ6100ST6D1 загварын 57 автобусыг нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>➢ Зорчигч тээвэр нэг-7<br>➢ Зорчигч тээвэр хоёр-11<br>➢ Зорчигч тээвэр гурав-4<br>➢ Зорчигч тээвэр дөрөв-8<br>➢ Зорчигч тээвэр тав-27 хүүхдийн автобусыг хүлээлцүүлсэн.<br>2024-2025 оны хичээлийн жилд Нийслэлийн боловсролын газраас 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 6/1495 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналын дагуу тус газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/100 дугаартай тушаалаар 7 чиглэлийн замналыг шинэчлэн баталсан бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс ерөнхий боловсролын 70 сургуулийн 67 чиглэлд 72 автобусаар үйлчилгээг эхлүүлсэн.<br>2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч төрийн өмчийн таван ОНӨААТҮГ, алслагдсан 3 дүүргийн 83 сургуулийн 69 чиглэлд 69 сургуулийн хүүхдийн автобусаар 1243150 хүүхэд тээвэрлэсэн байна. | | | | |
| **358** | 6.3.14.1. | **Заалт:** Цахилгаан эх үүсвэрээр ажилладаг тээврийн хэрэгслүүдийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж цэгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор байгуулна. | **НТБГ** | **НАБТГ** | 100 | |

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж суурилуулах ажлын хүрээнд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 1 сарын хугацаатай тендер зарлаж, Азсеть ХХК шалгарсан бөгөөд Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-т 12 ширхэг суурилуулснаас тус баазад-10 ширхэг, 20 дугаар хорооны Сэлбийн эцсийн буудалд-1 ширхэг, Дарь –Эхийн тоосгоны үйлдвэрийн эцсийн автобусны зогсоолд-1 ширхэг, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т 1 ширхэг нийт 13 цэнэглэх төхөөрөмж тус тус суурилуулсан байна.<br>БММЗ эцэс автобусны буудлын эцэст 6 цэнэглэх төхөөрөмж байршуулах хүчин чадалтай цахилгааны дэд төвийн угсралтын ажлын бүрэн хийгдэж дууссан. "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, хүлээн авах комисс томилох тушаалд санал аван ажиллаж байна. Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж суурилуулах ажлын хүрээнд Морингийн даваанд байрлах "Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ-ын байранд "Алтайн үндэс констракшн" ХХК-1 ширхэг ХТП, РП дэд өртөөд-1 ширхэг цахилгааны дэд төвийн угсралтын ажлын гүйцэтгэл 90%-тай явагдаж байна. | | | | |
| **359** | 6.3.14.2. | **Заалт:** Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ. | **НТБГ** | - | 100 | |
| | | Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд:<br>2020 онд 8 автобус:<br>➢ Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ нь БНХАУ-аас 2020 оны 01 дүгээр сард 8 их багтаамжийн /цахилгаан хөдөлгүүртэй автобус/<br>2021 онд 35 автобус:<br>➢ "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ нь Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 2021 оны 06 дугаар сард 35 их багтаамжийн автобус /цахилгаан хөдөлгүүртэй автобус/<br>2022 онд 71 автобус:<br>➢ 10 ширхэг давхар автобус /цахилгаан хөдөлгүүртэй автобус/<br>➢ 1 ширхэг их багтаамжийн цахилгаан автобус<br>➢ Xiamen golden dragon bus xml6105j15c загварын их багтаамжийн 60 автобус /Дизель/ | | | | |

<table>
<tr><th>№</th><th>ЗААЛТ</th><th>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР</th><th>ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА</th><th>ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА</th><th>ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ</th><th>ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ</th></tr>
<tr><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="3">2023 онд 364 автобус:<br>➢ 224 ширхэг /дизель/<br>➢ 55 ширхэг автобус /цахилгаан хөдөлгүүртэй автобус/ -/20 Дарханд өгсөн./<br>➢ 35 ширхэг автобус /дизель/<br>➢ 50 ширхэг каунти /дизель/<br>2024 онд 596 автобус:<br>➢ 565 ширхэг /дизель/<br>➢ 31 ширхэг /дизель/
<table>
<tr><th>Д/д</th><th>Евро-5 /Дизель/</th><th>Цахилгаан</th><th>Нийт</th></tr>
<tr><td>2020</td><td>-</td><td>8</td><td>8</td></tr>
<tr><td>2021</td><td>-</td><td>35</td><td>35</td></tr>
<tr><td>2022</td><td>60</td><td>11</td><td>71</td></tr>
<tr><td>2023</td><td>224+35+50</td><td>55</td><td>364</td></tr>
<tr><td>2024</td><td>565+31</td><td>-</td><td>596</td></tr>
<tr><td>Нийт</td><td>965</td><td>109</td><td>1074</td></tr>
</table>
Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор “Нийслэлийн Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажил”-ын хүрээнд 2020-2024 онд евро-5 /дизель/ маркийн 965 автобус, цахилгаан хөдөлгүүртэй 109 автобусаар нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог 1074 автобусаар нэмэгдүүлж ажилласан.</td><td></td><td></td></tr>
<tr><td rowspan="2">360</td><td rowspan="2">6.3.14.3.</td><td>Заалт: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хотын такси тээврийг хөгжүүлж, менежментийг сайжруулна.</td><td>НТБГ</td><td>-</td><td rowspan="2">70</td><td rowspan="2"></td></tr>
<tr><td colspan="3">Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Эрх шилжүүлэх тухай” өдрийн А/889 дүгээр захирамжаар Улаанбаатар хотын такси сервис төсөл хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг баталж, уг төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Улаанбаатар такси каб ХХК-д шилжүүлсэн.<br>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд таксийн үйлчилгээ эрхлэгч хувийн хэвшлийн 5 байгууллага өөрийн өмчөөр LPG хөдөлгүүртэй 74, бензин хөдөлгүүртэй 26 нийт 100 тээврийн хэрэгслээр нөхөн хангалт хийсэн.</td></tr>
</table>

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | Газрын даргын 2022 оны “Хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай” А/63 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн Такси дуудлагын үйлчилгээ эрхлэхээр хүсэлт ирүүлсэн Грийн прожект ХХК-ийн үйл ажиллагаанд гаргасан дүгнэлтийг тус газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээд 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, хяналт тавин ажиллаж байна. Тус газартай Такси үйлчилгээний 7, такси дуудлагын үйлчилгээ эрхлэгч 4 байгууллага “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан ажиллаж байна. Мөн таксийн дуудлагын үйлчилгээ эрхэлдэг Юбикаб ХХК, Билэгт дөлгөөн ХХК-ийн гэрээг 2024 оны 05 дугаар 01-ний өдрөөр дуусгавар болгон 2024 оны шинэчилсэн гэрээг байгуулсан.<br>Таксийн үйлчилгээ эрхлэгч Элит ноён такси ХХК-ийн гэрээг 2024 оны 09 дүгээр сарын 30-нд гэрээ цуцалсан тухай 01/03/2423 дугаартай албан бичиг хүргүүлсэн.<br>Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.12 дахь заалтад заасан нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тухай зохицуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. | | | | |
| **361** | 6.3.15.1 | **Заалт:**. “Агаарын дүүжин замын тээврийн төсөл”-ийг хэрэгжүүлнэ. | **НЗДТГ** | **НТБГ** | 70 | |
| | | “Агаарын дүүжин замын тээврийн төсөл”-ийн техник эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулахад шаардлагатай тоон мэдээллийг нэгтгэн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 2/504 дугаартай, 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/02/598 дугаартай, 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 01/02/1100 дугаартай албан бичгээр Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах төслийн нэгжид тус тус хүргүүлэн ажилласан.<br>Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн олон улсад ашиглагддаг стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцон стандартын төсөлд санал өгсөн. Мөн “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл“- ийн бүхээгийн рамыг цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан үзэгдэх орчин хязгаарлагдмал үед ялгарч харагдах үүднээс тод улаан (RAL 3020) өнгөөр хийх саналыг 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01/02/390 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн.<br>Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн газар, шороо, барилга угсралтын ажил Сонгино Хайрхан дүүргээс Хан-Уул дүүрэг Яармагийн эцсийн зогсоол хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна. | | | | |

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 362 | 6.3.15.2. | **Заалт:** Өндөр хүчин чадалтай нийтийн тээврийн төслийг хэрэгжүүлнэ. | **НЗДТГ** | **НТБГ** | 70 | |
| | | 1.Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн газар, шороо, барилга угсралтын ажил Сонгино Хайрхан дүүргээс Хан-Уул дүүрэг Яармагийн эцсийн зогсоол хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна.<br>2.Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх "Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар" 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг хэлэлцүүлэгт Far East BRT Planning Co Limited компани нийтийн тээврийн тусгай замын автобус зорчих төлөвлөсөн трассын талаар танилцуулсан ба Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Урьдчилсан байдлаар Ард-Аюушийн өргөн чөлөө, Их тойруу, Сүхбаатар талбай хүртэлх трассыг хийх ба 2025 оны 01 дүгээр сард загвар зураглалыг бэлэн болгож, 2025 оны 04 дүгээр сард нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтын ажлыг хийхээр төлөвлөсөн.<br>3.2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигтэй танилцаж, хуралдсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро барих төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан. 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, "Духуа Инженеринг" ХК ба түншлэл нь Улаанбаатар метро төслийн хүний нөөц бэлтгэх чиглэлд хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд метро жолоодлого, удирдлага, механик инженер, метроны цахилгаан, дохиолол, барилгын инженер гэсэн 4 чиглэлд сургалтын хөтөлбөрийг зөвлөх баг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус хөтөлбөртэй Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн холбогдох мэргэжилтнүүд танилцан, саналыг хүргүүлсэн. Одоогоор хамтарсан сургалтын хөтөлбөрийг | | | | |

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | боловсруулах болон хамтран ажиллах Бүгд Найрамдах Солонгос Улсын их сургуулийг тодорхойлох судалгаа, уулзалтууд хийгдсэн. | | | | |
| 363 | 6.3.16.1. | **Заалт:** Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал, зогсоолуудыг барьж, зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ. | **НТБГ** | **НӨУБХОМҮЦК ХХКГ** | 30 | |
| | | Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.3.1 дэх заалтад "Автобусны богино эргэлтийн терминалыг Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрдийн орчимд байгуулах" талаар тусгасан байдаг. Дээрх заалтын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зурагт нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна.<br>Мөн 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах" тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.<br>-Нийслэлийн засаг даргын тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2.5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулсан. | | | | |
| 365 | 6.3.18.1. | **Заалт:** Ачаа тээврийн шөнийн түгээлтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, менежментийг сайжруулна. | **НТБГ** | - | 100 | |
| | | Нийслэл хотын түгжрэлийг бууруулах төслийн нэгж, Захирагчийн ажлын алба хамтран 2023 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 12 цагаас Соёлын төв өргөөнд "Тээвэр логистикийн оновчтой шийдэл" сэдвээр худалдаа үйлчилгээ эрхлэгчидтэй уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад 9 дүүргийн худалдаа үйлчилгээ эрхлэгч 700 гаруй байгууллагын төлөөлөл оролцсон. Уулзалтаар бараа бүтээгдэхүүний шөнийн түгээлтийн талаар санал асуулга явуулахад худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх хувь нь боломжгүй гэсэн хариуг өгсөн. | | | | |

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | Уулзалт дээр Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар шөнийн түгээлтийг хийхгүй байхаар шийдвэр өгсөн.<br>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1381 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, “Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/04/1247 дугаартай албан бичиг, 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02/04/2134 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газарт тус тус хүргүүлсэн.<br>Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын Эрх зүйн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд Улаанбаатар хотын иргэдээс 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 23 хоногийн хугацаанд Нийтийн тээврийн бодлогын газрын https://transport.ub.gov.mn/ сайтаар “Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах талаар” судалгаа нийт 232 иргэнээс авсан. Судалгааны үр дүнд 198 иргэн буюу 85,5% нь ажлын өдрүүдийн оргил цаг буюу 6:00-10:00, 17:00-21:00 цагийн хооронд гол замуудаар хөдөлгөөнд оролцуулахыг хориглох шийдвэрийг дэмжсэн байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь энэ зүйлийн 22.1.13 дахь заалтыг үндэслэн энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулж болно гэсний дагуу журмын төслийг 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар батлуулах ажлыг бүрэн ханган ажилласан. | | | | |
| 366 | 6.3.18.2. | **Заалт:** Ачааны автомашины ЕС түр зөвшөөрлийн програм хангамжийг хэрэглээнд нэвтрүүлнэ. | **НТБГ** | - | 100 | |
| | | Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл” авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем” www.smartcar.mn–аар авч, түр зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсан.<br>Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрөл хүссэн иргэн аж ахуйн нэгж байгууллагын холбогдох материалыг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим | | | | |

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | үйлчилгээний систем" www.smartcar.mn-ээр хүлээн авч 2024 оны жилийн эцсийн тайлант хугацаанд нийт 6570 орчим тээврийн хэрэгсэлд үүнээс В ангиллын 1530, С ангиллын 4840, СЕ ангиллын 200 тээврийн хэрэгсэлд тус тус олгосон.<br>Төрийн Үйлчилгээний Цахим /ТҮЦ/ машинаар Нийслэлийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцох "ЕС" зөвшөөрөл нийт 15550 тээврийн хэрэгсэлд үүнээс В ангиллын 7515, С ангиллын 7260, СЕ ангиллын 775 тээврийн хэрэгсэлд тус тус олгож, мэдээ тайланг нэгтгэж ажилласан. | | | | |
| 367 | 6.3.18.3. | **Заалт:** "Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-ийн програм хангамжийг хэрэглээнд нэвтрүүлнэ. | **НТБГ** | - | 100 | |
| | | "Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-гийн программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж, 2024 оны жилийн эцсийн байдлаар www.autobox.mn сайтад нэвтрэх эрхээ авсан авто засварын үйлчилгээ эрхэлдэг 405 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 86662 автотээврийн хэрэгсэлд хийгдсэн засвар, үйлчилгээний мэдээллээ оруулан бүртгэлжүүлж хяналт тавьж ажилласан. Төрийн үйлчилгээний цахим портал www.e-mongolia.mn, Авто үйлчилгээний мэдээллийн сан www.autobox.mn веб сайтуудаар авто үйлчилгээний ангиллын гэрчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авч ажиллаж байна.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/112 тушаал "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам"-ын хэрэгжилтийг ханган онлайн бизнес төв, биетээр болон цахимаар хүсэлтийг хүлээн авч 2024 оны байдлаар 92 иргэн, 49 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 141 буюу 365 ажил үйлчилгээнд ангилал тогтоож, гэрээ байгуулан ажилласан. | | | | |
| 368 | 6.3.19.1. | **Заалт:** Удирдлагын төвд хяналтын дэлгэц байршуулж, нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд зорчигч тоолох систем суурилуулж, бүртгэл мэдээллийн програм хангамж нэвтрүүлнэ. | **НТБГ** | - | 100 | |
| | | Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд нийлүүлэгдсэн 631 автобусны дотоод камерын системийг удирдлагын нэгдсэн төвд холбох ажлыг хэрэгжүүлж байна. Мөн халаасны хулгайгаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран автобусны дотор талын камер хяналтыг хамтран ашиглахаар бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Нийтийн тээврийн төлбөрийн менежментийг сайжруулах төслийн хүрээнд Нийтийн тээврийн удирдлагын төвд хяналтын дэлгэц байршуулж, 1020 тээврийн хэрэгсэлд зорчигч тоолох төхөөрөмж суурилуулсан. | | | | |

| № | ЗААЛТ | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА | ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТ -ГЭЛИЙН ХУВЬ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | Улаанбаатар хотын нийтийн тээврийн төлбөрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд Ай Си Ти групп ХК-иас 1100 их багтаамжийн автобусанд зорчигч тоолох систем суурилуулахаар төлөвлөснөөс 1020 их багтаамжийн автобусанд суурилуулсан. Бүртгэл мэдээллийн программыг боловсруулж байна. | | | | |
| Хэрэгжилтийн дундаж хувь: /100%*8+70%*3+30%*1/ | | | | | 86.6 | |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ц.ОДМАНДАХ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ......
дугаар албан бичгийн 11 дүгээр хавсралт

# “НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 13 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу “Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагаанд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хүрээнд тус газраас 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ба хэрэгжилтийн дундаж 86.6 хувь байна. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 86.6 хувь байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр “Тодорхой үр дүнд хүрсэн” (зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай) үнэлгээтэй байна.

Үүнээс 100 хувь буюу “Үр дүнтэй” 8 арга хэмжээ, 70 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” 3 арга хэмжээ, 30 хувь буюу “Үр дүнгүй” 1 арга хэмжээ байна.

1.1.Бодлогын баримт бичгийн 6.3.14.3.”Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хотын такси тээврийг хөгжүүлж, менежментийг сайжруулна”, 6.3.15.1.“Агаарын дүүжин замын тээврийн төсөл”-ийг хэрэгжүүлнэ, 6.3.15.2.Өндөр хүчин чадалтай нийтийн тээврийн төслийг хэрэгжүүлнэ” гэсэн арга хэмжээнүүд 70 хувийн хэрэгжилттэй буюу үр дүнг эрчимжүүлэх шаардлагатай байна.

1.2.Бодлогын баримт бичгийн 6.3.16.1. “Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал, зогсоолуудыг барьж, зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн арга хэмжээ 30 хувийн биелэлттэй байгаа ба арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зурагт нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна.

Мөн 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг

зохион байгуулж "Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах" тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.

Нийслэлийн засаг даргын тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2.5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулсан.

## ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1.Даргын зөвлөлийн хурлаас уг арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнг Тээврийн бодлого, судалгааны хэлтсийн удирдлага, Зорчигч тээврийн хэлтсийн удирдлагуудад хүргүүлэх

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтсийн дарга, албан хаагчид 2025 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээрх 4 арга хэмжээг тусгах саналаа өгөх, тус арга хэмжээний шаардагдах төсөв, зорилтот түвшингээ зөв тодорхойлох, хамтран хэрэгжүүлэх холбогдох байгууллагуудтай уялдаа холбоогоо сайжруулах, Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид арга хэмжээг эрчимжүүлж, Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БЯМБАСҮРЭН